Аудитыг Баян суварга Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Юра, аудитор Х.Тунгалагтуяа, аудиторын туслах Ч.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Мөнхзул, захирал С.Должинсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Олон улсын жишиг, үндэсний стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээ үзүүлэх замаар Төр, засгийн байгууллагуудад хуулиар тогтоосон зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хэрэглэгчдэд үзүүлэх нийтлэг үйлчилгээг олон улсын жишиг, үндэсний стандартын түвшинд зохион байгуулж, үйлчилгээний ашигтай, хямд өртөг зардалтай дэвшилтэт хэлбэрүүдийг сонгож ажиллах;
- Төр, засгийн байгууллагын албан ажлын болон тусгай зориулалтын байрны нөхцөл, барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн ажиллагааг найдвартай хангах;
- Төр засгийн байгууллага, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн нийтлэг үйлчилгээг санхүүжүүлэх санхүү, нягтлан бодох бүртгэлийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх;
- Нийтлэг үйлчилгээний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулах, мэдээллийн технологи, дэвшилтэд арга, шинэ санааг нэвтрүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”



Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ТЗҮЭГ-ын Чанарын менежментийн хэлтсээс 2021 онд 3 бүлэг 19 асуудлаар дотоод хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөн хэрэгжүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 5,979,068.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 119,581.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 95,665.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 645,569.2 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,094.1	242,413.2	238,319.1
Авлага	102,657.0	8,058.0	(94,599.0)



Урьдчилгаа (урьдчилж гарсан зардал)	54,845.5	17,539.8	(37,305.7)
Бараа материал	1,181,054.8	1,117,821.1	(63,233.7)
Үндсэн хөрөнгө	27,961,117.7	27,272,367.8	(688,749.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>29,303,769.1</b>	<b>28,658,199.9</b>	<b>(645,569.2)</b>
Өр төлбөр	47,567.0	51,853.2	4,286.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	29,256,202.1	28,606,346.6	(649,855.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>29,303,769.1</b>	<b>28,658,199.9</b>	<b>(645,569.2)</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 242,413.2 мянган төгрөг болж 238,319.1 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн ордны мэдээллийн танхимын тохижилт, засварын ажлын барьцаа хөрөнгийн үлдэгдлийг бүртгэснээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 8,058.0 мянган төгрөг болж 94,599.0 мянган төгрөгөөр буурсан нь ЗГХЭГ-ын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх засварын ажлын санхүүжилтийн 91,490.0 мянган төгрөгийг барагдуулж, ТӨБЗГ-т төлөх түрээсийн орлогыг улсын төсөвт татан төвлөрүүлсэн 7,00.8 мянган төгрөгийг Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлагаар бүртгэж, хувь хүмүүсээс авах 1,050.0 мянган төгрөгийн авлага үүссэнээс тус тус шалтгаалжээ.

Урьдчилгаа, урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 17,539.8 мянган төгрөг болж 37,305.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд “Шинэ монгол гэр” ХХК-д 5 ханатай гэрийн урьдчилгаанд төлсөн 3,200.0 мянган төгрөг, “Хандок инженеринг” ХХК-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих, өргөх буулгах механизм, лифтийн сэлбэгийн урьдчилгаанд төлсөн 46,651.5 мянган төгрөгийг тус тус ажлын гүйцэтгэлийн тооцоогоор хааж, тайлант онд УИХ-ын серверийн өрөө, ТЗҮЭГ-ын хаалганы төлбөрт 8,256.4 мянган төгрөг, ус цэвэршүүлэгчийн үнийн 1,600.0 мянган төгрөг, техник хяналтын зардлын 7,683.4 мянган төгрөгийг тус тус урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэсэн нь шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,117,821.1 мянган төгрөг болж 63,233.7 мянган төгрөгөөр буурсан. Үүнд аж ахуйн материал 20,110.1 мянган төгрөг, хангамжийн материал 45,531.8 мянган төгрөг, бэлэн бүтээгдэхүүн 14,779.4 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 6,575.0 мянган төгрөг, бичиг хэргийн материал 620.3 мянган төгрөгөөр тус тус буурч бусад бараа материал 24,383.0 мянган төгрөгөөр өссөн нь шалтгаалжээ.

Тайлант онд ТЗҮЭГ-ын ӨХБЗ-ийн шийдвэрийг үндэслэн газрын даргын 2021 оны А/40 дүгээр тушаалаар нийт 108 нэрийн 124,810.5 мянган төгрөгийн хангамжийн материалыг акталж, А/41 дүгээр тушаалаар УИХ-ын Тамгын газраас шилжиж ирсэн 1,466.1 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, тус газрын хөрөнгөд давхар бүртгэгдсэн 6,271.7 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 27,272,367.8 мянган төгрөг болж 688,749.9 мянган төгрөгөөр буурсан.

Тайлант онд хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 27,972.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, өмнөх онд хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих, өргөх буулгах механизмын 130,700.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авч, ТӨБЗГ-ын 2021 оны 499 дүгээр тогтоолын дагуу 41,584.5 мянган төгрөгийн хөрөнгийг бусад үндсэн хөрөнгө дансанд балансаас балансад шилжүүлэн авч, өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу хангамжийн материалын дансанд бүртгэлтэй 23,942.9 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэжээ.

ТӨБЗГ-ын 2021 оны А-1/2203 дугаар албан бичгээр өгсөн шийдвэрийг үндэслэн 50,175.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасаж, давхар бүртгэгдсэн 17,490.0 мянган төгрөгийн хөрөнгийн хасалтыг хийсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 51,853.2 мянган төгрөг болж 4,286.2 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын байруудын нэгдсэн үйлчилгээний газарт төлөх үйлчилгээний төлбөрийн 8,827.8 мянган төгрөг, ТӨБЗГ-т төлөх түрээсийн төлбөрийн 20,463.1 мянган төгрөг, Монголын цахилгаан холбоонд төлөх ярианы төлбөрийн 3,043.3 төгрөг, бараа материалын төлбөрт төлөх 8,216.4 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх 1.4 мянган үлдэгдэлтэй гарсан нь шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 28,606,346.6 мянган төгрөг болж 649,855.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн бууралтаас шалтгаалжээ.

ТЗҮЭГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 352,223.3 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны болон нэмэлт санхүүжилт, төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 124,421.0 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж, эд хогшил, урсгал засвар, урсгал шилжүүлгийн зардлууд байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага 2021 оны төсвийн төслийг 4,678,012.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 430,776.9 мянган төгрөгөөр бууруулж 4,247,244.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,247,244.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 4,072,244.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 175,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,072,244.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 140,379.1 мянган төгрөг, нийт 4,212,623.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд бүрэн зарцуулсан байна. Тайлант онд Ковид-19 цар тахлаас шалтгаалан хурал цуглааны үйл ажиллагааг зогсоосны улмаас Төрийн ордны заал танхимын түрээсийн орлого тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийн зөрүү 69,971.4 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 43,477.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 15,989.0 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 9,973.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн орлогын эх үүсвэрт төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын 560,879.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшилд 101,520.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 8,431.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 8,431.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 188,316.2 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс худалдан авахад 245,089.5 мянган төгрөг, цэвэрлэгээний тоног төхөөрөмж худалдан авахад 8,195.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 84.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

ТЗҮЭГ-ын 2021 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дугаар заалтыг тус тус зөрчин ТЗҮЭГ-ын даргын 2020 оны Б/02 дугаар тушаалаар ажилтнуудын албан тушаалын цалинг 20 хувиар нэмэгдүүлэн тогтоож олгосон зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

2021 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар дээрх асуудлыг шалгаж үзэхэд 20 хувийн нэмэгдлийг үндсэн цалингаас хасаж, цалингийн нэмэгдэл хэсэгт нөхцөлийн нэмэгдэл нэрээр ТЗҮЭГ-ын даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар нийт ажиллагсдад 30 хүртэл хувиар тооцож олгон зөрчлийг дахин давтан гаргасан бөгөөд, ТЗҮЭГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/36 дугаар тушаалаар 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс нөхцөлийн нэмэгдэл олгохыг зогсоосон байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 8 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2021 онд нийт 7,715.1 сая төгрөгийн 208 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулж, 932.6 сая төгрөгийн 27 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн боловч зөрчил дахин давтагдан гарсан тул хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд төрийн ордны аж ахуй, үйлчилгээний бараа бүтээгдэхүүн нийлүүлэлтийн асуудлаар нэр бүхий 19 байгууллагатай “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулан 267,032.5 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 11 байгууллага, иргэнтэй “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ”, 5 иргэнтэй талбайн түрээсийн “Хамтрах ажиллах гэрээ” тус тус байгуулан нийт 113,043.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, гэрээг тухай бүр дүгнэж ажилласан байна.

Тайлант онд ЗГХЭГ-ын даргын 2021 оны 4, 90 дүгээр тушаалаар ТЕЗ-ийн эрх шилжүүлсэн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 435,000.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар батлагдсан. Үүнд:

- Төрийн ордны албан ажлын өрөө, мэдээллийн танхимын интерьер тохижилт, нийтийн эзэмшлийн талбайн засвар, тохижилтын ажилд- 400,000.0 мянган төгрөг;
- Төрийн ордны нийтийн эзэмшлийн талбай, инженерийн шугам сүлжээний засварын ажил гүйцэтгэхэд- 35.000.0 мянган төгрөг.

Гүйцэтгэлээр 427,413.2 мянган төгрөгийг зарцуулж, 7,586.8 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ТБОНӨХБАҮХАТХ тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 213,644.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулах, цалингийн нэмэгдэл, төсвийн гүйцэтгэл, НБББББ, дотоод хяналтын асуудлаар 4, нийт 6 зөвлөмж өгсөн.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 213,644.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудлыг 2022 оны 1 дүгээр сараас хэрэгжүүлж эхэлсэн, бусад 3 асуудлыг хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 актын биелэлт 100.0 хувь, шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээг хоцроож, 26 мэдээг байршуулаагүй зөрчилд өгсөн 1 албан шаардлагын биелэлт хангалтгүй буюу зөрчил бүрэн арилаагүй, 324,508.5 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг 2022 оны 1 дүгээр сараас хэрэгжүүлж эхэлсэн, 262,727.5 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	1	4,756.6	1	4,756.6			
Албан шаардлага	2	324,508.5	1	324,508.5			

Зөвлөмж	2	262,727.5	2	262,727.5			
<b>Нийт дүн</b>		<b>591,992.6</b>					

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 64,599.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,734.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 61,864.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын дансанд хангамжийн материалын ангилалд бүртгэвэл зохих 2,734.8 мянган төгрөгийн хөрөнгийг бэлэн бүтээгдэхүүний ангиллаар бүртгэснийг залруулсан.

### 4.2 Албан шаардлага

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2021 онд нийт 7,715.1 сая төгрөгийн 208 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулж, 932.6 сая төгрөгийн 27 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн боловч зөрчил дахин давтагдан гарсан тул хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөх.

### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн шинж чанартай 2 нэрийн 7,937.9 мянган төгрөгийн хөрөнгийг хангамжийн материалын дансанд бүртгэж тайлагнасан байна.

*Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэл болон ТЗҮЭГ-ын НБББББ-ийн 6 дугаар бүлгийн 6.5.4-д “Үндсэн хөрөнгө-Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгслүүд” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.*

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын НБББББ-ийн 6 дугаар бүлгийн 6.5.4-д заасныг мөрдөж, бараа материал, үндсэн хөрөнгийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах.

#### 2. Зардлын данстай холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

Тайлант онд өндөр насны тэтгэвэрт гарсан нэр бүхий 2 хүнд 53,926.8 мянган төгрөгийн тэтгэмж олгохдоо ажлаас чөлөөлсөн тушаал гаргаагүй, үргэлжлүүлэн ажиллуулж байна.

*Энэ нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгох журам”-ын 1.1-д “Төрийн албаны тухай хуулийн 46.2.2, 46.2.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж...” гэж заасантай нийцэхгүй байна.*

2.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 7, 2021 оны 43 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар	АХГ-2022/140/НА-СТА-ТШЗ	Бараа материалын дансанд хангамжийн материалын ангилалд бүртгэвэл зохих хөрөнгийг бэлэн бүтээгдэхүүний ангиллаар бүртгэсэн.	Аудитаар залруулсан	1	2,734.8	1	2,734.8						
2	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар	АХГ-2022/140/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн шинж чанартай 2 нэрийн 7,937.9 мянган төгрөгийн хөрөнгийг хангамжийн материалын дансанд бүртгэж тайлагнасан	Байгууллагын НБББББ-ийн холбогдох заалтыг мөрдөж, бараа материал, үндсэн хөрөнгийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах	1	7,937.9							1	7,937.9
3	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар	АХГ-2022/140/НА-СТА-ТШЗ	Тайлант онд өндөр насны тэтгэвэрт гарсан нэр бүхий 2 хүнд тэтгэмж олгоходоо ажлаас чөлөөлсөн тушаал гаргаагүй, үргэлжлүүлэн ажиллуулж байна	Засгийн газрын 2019 оны 7, 2021 оны 43 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллах	1	53,926.8							1	53,926.8
Дүн					3	64,599.5	1	2,734.8					2	61,864.7
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														



Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар	АХГ-2022/140/НА-СТА-ТХН	ТЗҮЭГ-ын 2021 онд 7,715.1 сая төгрөгийн 208 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулж, 932.6 сая төгрөгийн 27 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	Засгийн газраас тогтоосон төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг мөрдөх										
Дүн														
Нийт дүн					4	64,599.5	1	2,734.8			1		2	61,864.7



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 152/001700.54  
9017-2022/140/18-С10-7415

Улаанбаатар хот

Г Сахилгын шийтгэл ногдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 932,604,850.00 төгрөгийн 27 мэдээллийг хугацаа хоцроосон мэдээлж, өмнөх оны аудитаар өгсөн алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.9-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрчил гаргасан ерөнхий нягтлан бодогч Д.Ганчимэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга Ж.Тамир, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Г.Нэрж нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
“БАЯН СУВАРГА АУДИТ”  
ХХК-ИЙН АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА

Г.ЮРА

